



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1105

Номгон

Г Ингэний сүүний үйлдвэр, өвлийн хүлэмж, Г
1000 тн-ы мах ногооны зоорийг хувьчлах асуудлыг
судалж, танилцуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хөдөө аж ахуйн кластер төслийн ингэний сүүний үйлдвэр, өвлийн хүлэмж, 1000 тн-ы мах ногооны зоорь зэргийг хувьчлах асуудлыг судалж, танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Батсуурь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (Зөвшилцсөнөөр)

Т.Бат-Очир Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (Зөвшилцсөнөөр)

У.Балжинням Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Хишигбаяр "Ингэн эрдэнэ" ОНӨААТҮГ газрын захирал

Т.Саранчимэг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Отгонтөгс Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Норовринчин Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Ичинхорлоо Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын


хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Т.Мөнхзул Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

2.Хувьчлах асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

